



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

204 /204/

2021.12.20

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

“ШИЛЖИН ЯВАХ ЦОМ”-ЫН ЭЗДЭЭР БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБАНЫ БАГ ТАМИРЧИД ТОДОРЛОО



БХЯ-ны харьяа байгууллагууд жил бүр спортын зарим төрлөөр өрсөлддөг уламжлалтай бөгөөд эл тэмцээн өнөө жил Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, дартс гэсэн дөрвөн төрлөөр зохион

байгуулагдлаа. Тэмцээнд БХЯ, ЗХЖШ, ҮБХИС, “Алдар” спорт хороо, Цэргийн төв эмнэлэг, Цэргийн дуу бүжгийн эрмийн чуулга, “Соёмбо” редакц зэрэг 15 байгууллагын 19 баг тамирчин оролцож, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс багийн нийлбэр дүнгээр Барилга

захиалагчийн албаны баг тамирчид тэргүүн байрыг эзлэн “Шилжин явах цом”-ын эзэд болсон бол удаах байрт “Алдар” спорт хороо, гутгаар байрт Батлан хамгаалахын төв архивын баг тамирчид шалгарсан юм. Тэмцээний хаалтын ажиллагаанд Засгийн газрын

гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцож шилдгүүдэд шагнал гардуулсан бөгөөд тэрээр энэ үеэр хэлсэн үгэндээ “2022 онд бүх байгууллага Барилга захигчийн алба шиг спортлог байж хөдөлгөөний дутагдлаас сэргийлж эрүүл мэнддээ анхаарцгаая” хэмээн нийт оролцогчдод уриалав.

ИРЭХ ОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ОЛОН УЛСЫН ХУРЛЫН ТАЛААР ТАНИЛЦУУЛАВ



Монгол цэрэг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд ирэх оны 6 дугаар сард зохион байгуулагдах “Энхийг сахиулах ажиллагаанд Монгол эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулахаар төлөвлөдөг байгаа юм.

Эл хурлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд өнгөрсөн Баасан гарагт БХЯ-ны ГХАГ-ын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Т.Буянбат, ҮБХИС-

ийн сургалтын хэлтсийн дарга хурандаа Г.Болор нар болон албаны бусад хүмүүс ОХУ, АНУ, Хятад, Япон улсуудаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын болон цэргийн атташе нартай уулзалт хийлээ.

Энэ үеэр хурандаа Б.Бат-Эрдэнэ ирэх онд зохион байгуулагдах олон улсын хурлын талаар танилцуулга хийж, санал солилцлоо. Мөн Монгол Улсын Зэвсэгт хүчний эмэгтэй цэргийн алба хаагчдын талаар мэдээлэл өгсөн юм. Сонирхуулахад тус олон улсын хуралд оролцох урилгыг 37 улсад илгээгээд байгаа аж.

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай “UNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний сүүлийн цувраа өнгөрсөн Ням гарагт эх орондоо ирлээ. Тус цэргийн багийн эхний цуврааны бие бүрэлдэхүүн 10 дугаар сарын 20, хоёр дахь цуврааны бие бүрэлдэхүүн 11 дүгээр сарын 8, гурав дахь цуврааны бие бүрэлдэхүүн 11 дүгээр сарын 27-ны өдөр эх орондоо ирсэн билээ.

Өнгөрсөн нэг жил, хоёр сар

гаруйн хугацаанд даян дэлхийн энх амгалангийн үйл хэрэгт хүчин зүтгэж, НҮБ-ын болон монгол эх орон, төр, ард түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгээд ирсэн тэднийг ЗХЖШ-ын АУГ-ын дарга бригадын генерал С.Дашзэвэг тэргүүтэй албан тушаалтнууд угтан авлаа.

Энэхүү энхийг дэмжих ажиллагаанд үүргээ нэр төртэй гүйцэтгээд ирсэн цэнхэр дуулгалан энхийг сахиулагчдыг Монгол Улсын Онцгой комиссын шийдвэрээр “Багабаян-Энхийн төлөө цогцолбор”-т 10 хоногийн хугацаатайгаар тусгаарлана.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН
2.264.437 /69.6%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН
2,160,217 /66.4%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
850,958 26,1%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6766 +111

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
111

ЭДГЭРСЭН
6527

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 275,017,427

Эдгэрсэн
Нийт: 246,766,389

Нас барсан
Нийт: 5,370,457

1922 он.
Засгийн газрын 54 дүгээр хурлаар ЦЯЯ-ны сайдаар С.Магсаржавыг томилон, Д.Сүхбаатарыг Бүх цэргийн жанжны албан тушаалд үлдээжээ.

1924 он.
Улсын бага хурлын тэргүүлэгчдээс Ардын цэргийн жанжин туг бүтээх шийдвэр гарчээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-23

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,851.0
EUR	3,171.0	3,242.0
CNY	444.30	447.70
RUB	37.60	39.10
JPY	24.77	25.36
KRW	2.36	2.45

ЗУРХАЙ

2021.12.20 ДАВАА ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 16/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХАР БАР ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.38-17.01
Барилдлага:
Рашаан
Шүтэн барилдлага:
Өтлөх үхэхүй
Суудал:
Төмөр

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.

Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн.

Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс засуулбал өвчин ирнэ

цахим шууданд

ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТӨВИЙН ЭЭЛЖИТ ТӨГСӨЛТ



ЗХЖШ-ын Гадаад хэлний сургалтын төвийн англи хэлний дунд шатны 67 дахь удаагийн төгсөлтийн ёслолын арга хэмжээ энэ сарын 17-ны өдөр зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд ЗХЖШ-ын I орлогч дарга хурандаа С.Ганбямба, Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга хурандаа Ш.Гантулга, Зэвсэгт хүчний Гадаад хэлний

сургалтын төвийн дарга дэд хурандаа Ч.Тунгалаг нар оролцож, төгсөгчдөд баяр хүргэн, сургалтыг цар тахлын амаргүй нөхцөлд тасралтгүй явуулсан багш нарт талархал илэрхийллээ.

Эл Гадаад хэлний сургалтын төв нь 2021 онд 3 удаагийн давтамжтай анхан шатны 8, бэлтгэл дунд шатны 9, дунд шатны 6 буюу нийт 23 дамжааны сургалтыг

зохион байгуулж 11040 цагийн ачааллыг гүйцэтгэсэн ба сургалтад давхардсан тоогоор нийт 172 офицер, 80 ахлагч хамрагджээ. Харин англи хэлний дунд шатны 67 дахь төгсөлтөд 17 офицер, ахлагч багтах бөгөөд Зэвсэгт хүчнээс 14, Төрийн тусгай хамгаалалтын газраас 2, Цагдаагийн ерөнхий газраас 1 алба хаагч ийнхүү амжилттай төгсжээ.

Гадаад хэлний сургалтын төв нь цэргийн алба хаагчдыг гадаад, дотоодын цэргийн сургууль, дамжаа, НҮБ болон олон улсын бусад ажиллагаанд хамрагдахад шаардлагатай англи хэлний сургалтыг чанартай зохион байгуулах, мэдлэгийн түвшинг олон улсын жишигт нийцүүлэн бодитоор үнэлэх зорилготой юм.

ЖУБА БҮСИЙН КОМАНДЛАГЧ БРИГАДЫН ГЕНЕРАЛ Б.ЭРДЭНЭБАТ ЛАЙНЯ СУУРИНЫ УДИРДЛАГА, НУТГИЙН ИРГЭДТЭЙ УУЛЗЛАА



Жуба бүсийн командлагч бригадын генерал Б.Эрдэнэбат Өмнөд бүсийн Лайня сууринд түр ажиллагааны бааз байгуулан үүрэг гүйцэтгэж буй өөрийн командлалын харьяа Руанда улсын III мотобуудлагын батальоны хээрийн байрлалт, үйл ажиллагаатай танилцлаа.

НҮБ-ын Минатэй тэмцэх алба Лайня суурингаас Вондуруба суурин хүртэл 29 км замын дагуу тэсэрч, дэлбэрэх зүйлсийг илрүүлж устган орон нутгийн иргэдийг аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй ба минатэй тэмцэх албаны ажилчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор Жуба бүсийн Руанда улсын III мотобуудлагын батальоноос түр ажиллагааны бааз

төлөөлөлтэй уулзав.

Уулзалтын үеэр аймгийн засаг дарга энх тайван, олон нийтийн сайн сайхны төлөө хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлээд овог аймгуудын мөргөлдөөний үеэр нөхрөө алдсан эмэгтэйчүүд, залуучуудын бүлгүүдийг дэмжих, дотоод дүрвэгсдэд



байгуулсан юм.

Айлчлалын үеэр тэрээр орон нутгийн засаг дарга ноён Эммануэль Фенис, "Бар дивиз"-ийн командлагч бригадын генерал Уильям Мвун, бусад албаны хүмүүс болон нутгийн иргэдийн

хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг хүслээ. Уулзалтын төгсгөлд бригадын генерал Б.Эрдэнэбат нутгийн иргэдэд найрсгаар хүлээн авсанд талархал илэрхийлж, эрүүл энх, амар амгаланг хүсэн ерөөв.

ТӨГСӨГЧДИЙН НЭРЭМЖИТ ШАТРЫН СПОТООР ...



Цэргийн доторх улс төрийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд ЦНДС-ийн Улс төрийн ангийн 1983 оны төгсөгчдийн нэрэмжит 2021 оны шатрын аварга шалгаруулах тэмцээн Монгол цэргийн музейд зохион байгуулагдлаа.

Энэхүү тэмцээнийг

Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл ТББ болон нэгдсэн хурандаа Ч.Цог, Л.Чулуунбаатар, бэлтгэл дэд хурандаа Ё.Бямбадорж нарын 1983 оны Улс төрийн ангийн төгсөгчид уламжлал ёсоороо ивээн тэтгэн, 5 дахь жилдээ зохион байгуулав. Энэ жилийн тэмцээнд 30 шахам ахмад

төгсөгч оролцсон бөгөөд нээлтийн ажиллагаа төрөлх сургууль болон үе үеийн төгсөгчдийнхөө төлөө сэтгэл зүтгэл, үйл хэргээ зориулж явдаг цөөнгүй ахмадуудыг шагнаж урамшуулснаар эхэлсэн юм. ЦЕДС, ЦНДС, ЦИС, БХИС-ийн Улс төрийн анги төгсөгчид, Львов, Минск хотын цэргийн сургуулийн улс төр, соёлын ажилтнууд жил бүр энэхүү тэмцээндээ идэвхтэй оролцдог бөгөөд бусад мэргэжлийн цэргийн төгсөгчид, ахмадуудын эвсэл холбоод спортын төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, үе үеийн төгсөгчид өрсөлдөн наадахаас гадна уулзацгааж, залуу нас, оюутан цаг, ажил амьдралын талаар яриа өрнүүлдэг нь оролцогчдын сэтгэлд нийцсэн, басхүү тэдний чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх нэгэн сайхан үйл явдал болдог ажээ.

АЛБА, САЛБАР СУРТАЛЧЛАХ АЯН ҮРГЭЛЖИЛСЭЭР...

Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу алба, салбар сурталчлах тэмцээний удирдамжийн хүрээнд Инженер сапёрын ротын цэргийн гэрээт алба хаагчид ангийн байнгын бие бүрэлдэхүүний дунд "Сагсан бөмбөг"-ийн аварга шалгаруулах тэмцээн, "Үндэсний өв соёл", "Гар барилдаан", "Галын бэлтгэл" нормативын тэмцээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулж явууллаа. Эдгээр тэмцээнд бие бүрэлдэхүүн идэвх санаачилгатай оролцсон бөгөөд сагсан бөмбөгийн төрлөөр тэргүүн байрт Инженер төхөөрөмжийн батальон, дэд байрт Штаб, гутгаар байрт Инженер сапёрын рот шалгарлаа.

"Үндэсний өв соёл" тэмцээн нь "Сур харваа", "Шагай шүүрэх", "Сээр цохих" зэрэг үе шатуудаас бүрдсэн бөгөөд тус тэмцээний тэргүүн байрт Инженер төхөөрөмжийн батальон, дэд байрт хөгжим,



гутгаар байрт Инженер сапёрын рот шалгарсан бол "Гар барилдаан"-ы төрлөөр тэргүүн байрт ахлах дэслэгч Г.Батболд, дэд байрт ахмад О.Мягмарцэрэн, удаах байрт ахмад Б.Дүүрэнбилэг нар шалгарлаа. Мөн "Галын бэлтгэл" нормативын

тэмцээнд Инженер сапёрын батальон тэргүүлж "Автомат буу задаргаа"-ны төрөлд хувийн амжилтаар ахлагч Э.Жавзанжамъян, "Магазин сумлагаа"-нд дэслэгч Р.Билэг нар тэргүүлсэн юм.

Дэслэгч Р.БИЛЭГ

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХАНДИВЛАВ



Дэлхий нийтэд тархаад байгаа Ковид-19 цар тахлыг даван туулах, коронавирусын халдвар авсан өвчтөнүүдийг эмчлэх улсын ачааллын чамлахааргүй хувийг

нуруундаа үүрч яваа Цэргийн төв эмнэлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд зориулж Малайз Улсын "Радансе Ассетс Берхад" болон Монгол Улсын

"Гэрэлт ассемоур трейдинг" ХХК-аас 130 сая төгрөгийн өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн буцалтгүй тусламжийг гардуулан өглөө.

Хоёр орны иргэдийн найрсаг сэтгэлийн илэрхийлэл болсон энэхүү хандивын үйл ажиллагаа Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын санаачилгаар хэрэгжсэн бөгөөд вирусээр өвчлөгсдийн зайлшгүй хэрэгцээт тариа, нэг удаагийн тариур, амны хаалт зэрэг тусламжийн бараа бүтээгдэхүүнийг "Гэрэлт ассемоур юнайтед" ХХК-ны гүйцэтгэх захирал Б.Амарбаясгалан, Захирлуудын зөвлөлийн дарга Х.Биндэрээ тэргүүтэй удирдлагууд хүлээлгэн өгсөн юм. Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч хурандаа Б.Энх-Од тэдэнд талархлаа илэрхийлээд оны төгсгөл болоод хэрэглээний эм тариа хомсодсон үед ирж буй энэ тусламж үнэхээр хэрэгцээтэй, олон хүний амь насыг аврахуйц буянтай ажил боллоо гэдгийг тодотгов.

Д.ГҮНЖИЛМАА

АЛБА ХААГЧДЫН ХУРУУНЫ ХЭЭГ БҮРТГЭЛЖҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн захирагчийн зөвлөлөөс санаачлан ангийн нийт алба хаагчдыг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан

сэргийлэх зорилгоор Баян-Өлгий аймгийн Шүүхийн шинжилгээний албатай хамтран алба хаагч нэг бүрийн хурууны хээг дардсаар баталгаажуулан

бүртгэлжүүлэв. Ингэснээр алба хаагчдыг санаатай болон санамсаргүй байдлаар гэмт хэрэгт холбогдох эрсдэлээс хамгаалах юм.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)